



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2020 оны 09 сарын 29 өдөр

Дугаар А/ЧНЗ

Арвайхээр


Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны “Зорилтот жил болгон зарлах тухай” 12/04 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын 2020 оны “Зорилтот жилийн төлөвлөгөө батлах тухай” А/102 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Зорилтот жилийн хүрээнд орон нутгийн үйлдвэрлэгчдийн бүтээгдэхүүнээр бүрдүүлсэн бэлгийн багцыг худалдан авч хэрэглэгчдэд танилцуулахад 1,230,000 (нэг сая хоёр зуун гучин мянга), Арвайхээр суманд баригдсан “Өвөрхангайд үйлдвэрлэв” худалдааны төвд уран зураг өлгөх зориулалтын дэгээ, хавчаар бусад материал худалдан авахад шаардагдах 195,600 (нэг зуун ерэн таван мянга зургаан зуу) төгрөгийг тус тус зарцуулсугай.

2.Дээрх 1,425,600 (нэг сая дөрвөн зуун хорин таван мянга зургаан зуу) төгрөгийг орон нутгийн төсөвт батлагдсан зорилтот жилийн ажлын зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ц.Ганболд)-т зөвшөөрсүгэй.

ОРЛОГЧ



О.БАТЖАРГАЛ

011100977